



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/133

Мандалговь

Г Хөдөлгөөн өрнүүлэх тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нүүдэлчин Монголчуудын эв нэгдэл, нэгдмэл зорилгыг агуулсан ардын наадам цэнгүүн буюу хөдөлгөөний урлагийн гайхамшигт төрөл болсон "Тойром бүжиг"-ийг бүх нийтээрээ сурах хөдөлгөөнийг 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 01-ний хооронд өрнүүлсүгэй.

Хоёр. Энэхүү хөдөлгөөний хүрээнд Дундговь Урлаг сангаас санаачилсан хөгжмийн зохиолч Г.Төвшинтөр, яруу найрагч П.Нямлхагва, бүжиг дэглээч У.Өнөрбаяр нарын "Дундговийн тойром бүжиг" шинэ уран бүтээлийг аймгийн брэнд болгон нийтэд түгээн дэлгэрүүлэх төслийг хэрэгжүүлсүгэй.

Гурав. "Дундговийн тойром бүжиг"-ийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл урлагийн газар /Ц.Бумангэрэл/, Төв Халхын дуулалт жүжгийн театр /Д.Доржсүрэн/, "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театр /А.Ууганбаяр/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Ганзориг/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Төслийн багтай хамтран ажиллаж, удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /А.Нарантуяа/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200458